



СИТИ ИХ СУРГУУЛЬ

# СИТИ ИХ СУРГУУЛЬ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

24 сарын 13:09

A/76

Уланбаатар хот

СИТИ их сургуульд 2024-2025 оны хичээлийн жилд  
оюутан элсүүлэх журам батлах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, Дээд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 болон 18.2 дахь хэсэг, БШУЯ-ны сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2024 оны A/143 дугаар тушаалын хавсралт "Оюутан элсүүлэх журам", 2024 оны "Босго оноо тогтоох тухай" A/170 дугаар тушаалын хавсралт, "СИТИ" Их сургуулийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "СИТИ" их сургуулийн оюутан элсүүлэх журмыг хавсралт ёсоор баталсугай.
2. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Сургалтын бодлого, зохицуулалтын газар /Ц.Дамдинсүрэн/-д даалгасугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "СИТИ" их сургуулийн Ерөнхийлөгчийн 2023 оны A/29 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Ц.БАЙГАЛМАА



СИТИ их сургуулийн  
Ерөнхийлөгчийн  
2024 оны А/76 дугаар  
тушаалын хавсралт

## СИТИ ИХ СУРГУУЛЬД 2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. СИТИ их сургуульд оюутан элсүүлэх үйл ажиллагаанд БШУ-ны Сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2024 оны А/143 дугаар тушаалын хавсралт "Оюутан элсүүлэх журам", 2024 оны "Босго оноо тогтоох тухай" А/97 дугаар тушаалын хавсралт, "Боловсролын тухай", "Дээд боловсролын тухай" хууль болон бусад холбогдох дүрэм, журамд нийцүүлэн боловсруулсан энэхүү журмыг баримтлана.

1.2. Оюутан элсүүлэх ажлын гол зорилго нь шалгуулагчдын ерөнхий боловсролын түвшин, мэдлэг, чадвар, авьяасыг бодитойгоор үнэлж, цаашид амжилттай суралцах чадвартай хүмүүсийг сонгон элсүүлэхэд оршино.

1.3. Оюутан элсүүлэх үйл ажиллагаа нь ил тод, шударга, тэгш хамруулсан байх зарчмыг хангана

1.4. Оюутан элсүүлэх үйл ажиллагаатай холбоотой нийтэд чиглэсэн мэдээлэл, зар сурталчилгаа үнэн зөв, ойлгомжтой, хүртээмжтэй байна

1.5. Оюутан элсүүлэх үйл ажиллагааг цахимаар болон танхимаар зохион байгуулна.

### Хоёр. Бүртгүүлэгчид тавих шаардлага

2.1. СИТИ их сургуульд бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролтой иргэнийг бакалаврын хөтөлбөрт элсүүлнэ.

2.2. Бүртгүүлэгч нь суралцахаар сонгосон мэргэжил/хөтөлбөр/-ийн онцлогт тохирох элсэлтийн ерөнхий шалгалт /цаашид ЭЕШ гэх-/ын босго онооны шаардлагыг хангасан байхаас гадна зарим мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/-ийн хувьд ур чадварын шалгалтын босго онооны шаардлагыг хангасан байна.

2.3. Бүртгүүлэгч нь Боловсролын үнэлгээний төвөөс цахимаар олгосон батламжтай байна.

2.4. Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлээр элсэгчдэд тавих шаардлагыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоосны дагуу элсүүлнэ.

2.5.Бакалаврын хөтөлбөрт суралцах хүсэлтэй иргэнийг дараах шалгуурын аль нэгийг хангасан тохиолдолд ЭЕШ-ын оноо шаардахгүйгээр элсүүлнэ. Үүнд:

2.5.1.Дэд бакалавр болон бакалаврын боловсролтой иргэн;

2.5.2.Политехник коллеж, шаталсан сургалттай дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгч тухайн мэргэжлийн чиглэлээр дэвшин суралцах суралцагч;

2.5.3.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн олон улсын болон улсын төрөлжсөн олипиадын эхний 5 байрт шалгарсан иргэн;

2.5.4.Гадаад болон дотоодын ерөнхий боловсролын сургуульд суралцаж бүрэн дунд боловсрол эзэмшин, олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг, шалгалтын дүн, оноог Боловсролын үнэлгээний төвөөр дүйцүүлэн тооцуулж батламж авсан иргэн;

2.5.5.Гадаадын аль нэг улсын дээд боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагын бакалаврын хөтөлбөрт шилжин суралцах иргэн;

2.5.6.Элсэн суралцах мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/-ээр 5-аас доошгүй жил ажилласан, 30-аас дээш насны иргэн;

2.6.Монгол улсын олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын сургууль төгсөгч нь олон улсын шалгалтын үнэлгээгээ ЭЕШ-ын үнэлгээнд дүйцүүлэх эсвэл ЭЕШ-д хамрагдаж авсан онооныхоо аль өндөр оноогоороо элсэн орж болно.

2.7.ЭЕШ-ын батламж хуудас нь шалгалт өгсөн өдрөөс хойш 2 жил 8 сарын хугацаанд хүчинтэй байна.

#### **Гурав. Элсэлтийн үйл ажиллагааны зохион байгуулалт**

3.1.СИТИ их сургуулийн Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан Элсэлтийн комисс элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулна. Элсэлтийн комисс нь элсэлтийн үйл ажиллагааг шударга, хууль журмын дагуу явуулах үүрэгтэй.

3.2.Энэхүү журмын 2-т заасан шаардлага, босгыг хангасан бүртгүүлэгчийн хүсэлтийг хүлээн авч элсүүлнэ.

3.3.Энэ журмын 2.5.6-д заасан бүртгүүлэгчийн ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгал төлсөн лавлагаа, өргөдөл болон эсээ /бүртгүүлэгч өөрийн суралцах бэлтгэл хангасан байдал, авьяас чадвар, туршлага, хувийн зан чанар, хэрхэн суралцахаа илэрхийлсэн байна/ зэргийг үндэслэн элсүүлнэ.

3.4.Ур чадварын шалгалт авах мэргэжил /хөтөлбөр/-ийн жагсаалтад буй сургалтын хөтөлбөрүүдээр ур чадварын шалгалтыг зохион байгуулна.

3.4.1.Ур чадварын шалгалтыг 2024 оны 6 дугаар сарын 17-21-ний өдрүүдэд Улаанбаатар хотод сургууль дээр зохион байгуулна. Зайлшгүй шаардлагатай нөхцөл цахимаар зохион байгуулж болно.

3.4.2.Ур чадварын шалгалтыг мэргэжил /хөтөлбөр/ тус бүрээр батлагдсан комисс зохион байгуулж авна.

3.4.3.Ур чадварын шалгалтад тухайн хөтөлбөрт элсэх ЭЕШ-ын босго оноог хангасан оюутанг оруулна.

3.5.Оюутан элсүүлэх мэргэжлийн чиглэл/хөтөлбөр/-ийн индекс, суралцах хугацаа, хэлбэр, нийт судлах багц цаг, ЭЕШ-ын хичээлийн босго оноо, ур чадварын шалгалтын босго оноо зэрэг мэдээллийг сургуулийн цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээнэ.

3.6.Элсэлтийн бүртгэлийн хураамж нь элсэлтийн комиссын бүртгэл хийх, бичиг баримт хүлээн авах, үнэлэх, шалгах зэрэг үйл ажиллагааны зардалд зарцуулагдах тул элссэн эсэхээс үл хамааран буцаан олгогдохгүй. Харин бүртгэлийн хураамж төлсөн бол сургуулийн санал болгож байгаа бусад мэргэжлийн хөтөлбөрөөс сонгох давуу тал болно.

3.7.Элсэлтийн үйл ажиллагааг жилд 2 удаа зохион байгуулна.

3.7.1.Элсэлтийн хяналтын тоог сургуулийн Удирдах зөвлөл /цаашид УЗ/ гэх-өөр хэлэлцүүлэн батлуулна.

3.7.2.Намрын буюу эхний элсэлтийг УЗ-өөс баталсан хяналтын тоонд багтаан зохион байгуулна.

3.7.3.Өвлийн буюу 2 дахь удаагийн элсэлтийг УЗ-аас намар баталсан элсэлтийн хяналтын тоог гүйцээх байдлаар зохион байгуулна. Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжил /хөтөлбөр/-ээр нэмэлт элсэлт авах хяналтын тоог УЗ-өөр хэлэлцүүлэн батлуулж элсэлт авна.

3.8.Гадаадын иргэдийг сургахад дараах арга хэмжээг авна. Үүнд:

3.8.1.Элсэхийг хүссэн гадаадын иргэнээс авсан монгол хэлний мэдлэг, чадварын шалгалт, эсвэл англи хэлний олон улсын шалгалтын оноог харгалзан элсүүлнэ.

3.8.2.Монгол хэлний түвшин тогтоох шалгалтын шаардлага хангаагүй гадаадын иргэнийг монгол хэлний бэлтгэл ангид бүртгэн суралцуулна.

3.8.3. Энэ журмын 3.8.1-д заасан шалгалтын даалгавар "Монгол хэлний тухай" хуулийн 22 дугаар зүйлд заасан байгууллагаас боловсруулсан гадаадын иргэнээс авах монгол хэлний түвшин тогтоо шалгалтын агуулгын хүрээнд боловсруулсан байна.

3.8.4. Монгол хэлний түвшин тогтоо шалгалтын шаардлага хангаагүй гадаадын иргэнийг монгол хэлний бэлтгэл ангид бүртгэн суралцуулна.

#### Дөрөв. ЭЕШ-ын нэр, босго оноо

№	Индекс	Хөтөлбөрийн нэр	ЭЕШ-1	Босго оноо	ЭЕШ-2	Босго оноо
1	011201	Багш сургуулийн ёмнөх боловсрол	Монгол хэл, Нийгэм судлал	440	Ур чадварын шалгалт	480
2	011301	Багш, бага боловсрол	Монгол хэл, Математик	450	Ур чадварын шалгалт	480
3	011424	Багш, хөгжмийн боловсрол	Монгол хэл, Нийгэм судлал	450	Ур чадварын шалгалт	480
4	011425	Багш, бүжгийн боловсрол	Монгол хэл, Нийгэм судлал	450	Ур чадварын шалгалт	480
5	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Англи хэл, Орос хэл	480	Монгол хэл, нийгэм судлал	480
6	021105	График дизайн	Математик, Англи хэл	450	Ур чадварын шалгалт	480
7	021202	Хувцасны дизайн	Матемитик, Англи хэл	450	Ур чадварын шалгалт	480
8	021204	Интерьер дизайн	Математик, Англи хэл	450	Ур чадварын шалгалт	480
9	021501	Хөгжмийн урлаг	Монгол хэл, Нийгэм судлал	450	Ур чадварын шалгалт	480
10	021508	Дуулах урлаг	Монгол хэл, Нийгэм судлал	450	Ур чадварын шалгалт	480
11	021510	Жүжиглэх урлаг	Монгол хэл, Нийгэм судлал	450	Ур чадварын шалгалт	480
12	021512	Найруулах урлаг	Монгол хэл, Нийгэм судлал	450	Ур чадварын шалгалт	480
13	021513	Бүжгийн урлаг	Монгол хэл, Нийгэм судлал	450	Ур чадварын шалгалт	480
14	023101	Гадаад хэлний орчуулга	Англи хэл, Орос хэл	480	Нийгэм судлал, Монгол хэл	480
15	028803	Гоо заслын урлаг, технологи	Монгол хэл, Нийгэм судлал	480	Ур чадварын шалгалт	480
16	031301	Сэтгэл судлал	Нийгэм судлал, Математик	480	Монгол хэл, Англи хэл	440
17	032101	Сэтгүүл зүй	Монгол хэл, Нийгэм судлал	480	Ур чадварын шалгалт	480
18	041101	Нягтлан бодох бүртгэл	Математик	480	Англи хэл, Нийгэм судлал	480
19	041303	Менежмент	Математик	480	Англи хэл, Нийгэс судлал	480

20	041401	Маркетинг	Математик	480	Англи хэл, Нийгэм судлал	480
21	042101	Эрх зүй	Нийгэм судлал	480	Математик, Англи хэл	480
22	061302	Программ хангамж	Физик, Математик	480	Нийгэм судлал, Англи хэл	450
23	073104	Архитектур	Математик, Физик	480	Ур чадварын шалгалт	480
24	073204	Барилгын инжернерчлэл	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	480
25	091301	Сувилахуй	Хими, математик	400	Ур чадварын шалгалт	480
26	101301	Зочлох үйлчилгээ	Нийгэм судлал	480	Монгол хэл, Түүх	480
27	101501	Аялал жуулчлал	Математик, Монгол хэл	480	Нийгэм судлал, Англи хэл	480
28	104104	Агаарын тээврийн үйчилгээ	Англи хэл, Нийгэм судлал	480	Ур чадварын шалгалт	480
29	041601	Худалдаа	Нийгэм судлал	480	Англи хэл, Монгол хэл	480

#### Тав.Ур чадварын шалгалт авах

5.1.Ур чадварын шалгалтыг дараах бүлгээр зохион байгуулна. Үүнд:

№	Мэргэжлийн индекс	Хөтөлбөрийн нэр	Шалгалтын хэлбэр	Ур чадвар, шалгуур	Босго оноо
<b>Багш мэргэжил</b>					
1	011201	Багш сургуулийн өмнөх насны Боловсрол		-харилцааны зв дүй (бусдыг сонсох, ойлгох,өөрийгөө илэрхийлэх, бусдад туслах, зелдэг нөхөрсөг хандах, шударга, зарчимч байх) -Багш мэргэжлийн тухай ойлголт, сэтгэцийн байдал, хоолойн өнгө	480
2	011301	Багш, бага боловсрол	-Бичгийн ажил -Тест -Ярилцлага -Кейс дээр ажиллах	-Дуулах -Хөгжимдэх -Урлагийн тухай ярилцлага	480
3	011424	Багш,хөгжмийн боловсрол		-Бүжиглэх -Сонсгол, ритм -Анхаарал -Ярилцлага	480
4	011425	Багш, бүжгийн боловсрол		Хөдөлгөөний эвсэл Хөгжмийн сонсгол, хэмнэлийн мэдрэмж, ритм, ой тогтоолт	480

Зураг, дизайнчлал					
5	021106	График дизайн			
6	021202	Хувцасны дизайн			
7	021204	Интерьер дизайн	-Натюрморт зурах -Сэдэвт зохиомж зурах	-Хар зураг, зохиомж, бүтээлч сэтгэлгээ -Гүйцэтгэл	480
8	028803	Гоо заслын урлаг, технологи			
9	073104	Архитектур			
Урлаг соёл					
10	021508	Дуулах урлаг	Дуулах, бүжиглэх	Дуулах ур чадвар /100 оноо/, егөгдсөн этюд /100 оноо/, Шүлэг, мнологи /100 оноо/, хөдөлгөөний звсэл бүжиг /50 оноо/, дуулах чадвар /50 оноо/, сонсгал, ритм /50 оноо/, ярилцлага /30 оноо/	480
11	021510	Жүжиглэх урлаг		Этюд/100 оноо/, егөгдсөн этюд /100 оноо/, шүлэг, мнологи /100 оноо/, хөдөлгөөний звсэл бүжиг /50 оноо/, дуулах чадвар /50 оноо/, сонсгал, ритм /50 оноо/, ярилцлага /30 оноо/	
12	021512	Найруулах урлаг	Дуулах Бүжиглэх, жүжиглэх, Анхаарал Хөгжмийн сонсгал, ритм	Бүжиглэх /50 оноо/, дуулах чадвар /50 оноо/, сонсгал, ритм /50 оноо/, ярилцлага /30 оноо/	480
13	021513	Бүжгийн урлаг	Бүжиглэх, жүжиглэх	Бүжиглэх чадвар/100 оноо/, уян хатан чанар /100 оноо/, Сонсгал хэмнэл ой тогтоолт /100 оноо/, хөгжмийн мэдрэмж /100 оноо/ ярилцлага /80 оноо/	480
14	104104	Агаарын тээврийн үйлчилгээ	Бичгийн ажил, тест, ярилцлага, кейс дээр ажиллах	-харилцааны эв дүй (бусдыг сонсох, ойлгох, өөрийгөө илэрхийлэх, бусдад туслах, зелдэг нөхөрсөг хандах, шударга зарчимч байх), мэргэжлийн тухай ойлголт, сэтгэцийн байдал, хоолойн өнгө	480
Анагаах ухаан					
15	091301	Сувилахуй	Асуумж, тест, эсээ бичих	Мэргэжил болон эрүүл мэндийн ерөнхий мэдлэг, ярилцлага Хүнлэн, эрэнэнгүй, ёс зүй, харилцааны эв дүй /бусдыг сонсох, ойлгох,	480

				өөрийгөө илэрхийлэх, бусдад туслах, зелдэг, нөхөрсөг хандах, шударга зарчимч байх/	
--	--	--	--	---	--

### **Зургаа. Оюутан элсүүлэх тэтгэлэгт нөхцөл**

#### **6.1. Дараах нөхцлөөр тэтгэлэг олгоно.**

- ЭЕШ-д өндөр оноо авсан бол эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрт дараах байдлаар тэтгэлэг олгоно.Үүнд:  
 -700-аас дээш бол 70 хувь  
 -650-699 оноотой бол 60 хувь  
 -600-649 оноотой бол 50 хувь
- Тухайн чиглэлээр аймаг, хот, улсын хэмжээний уралдаан, тэмцээнд эхний 5 байрт шалгарч байсан бол 30-50 хүртэл хувь
- СИТИ их сургуулиас суралцах эрхийн урилга хулээн авсан бол 5-20 хүртэл хувь
- ЕБС-ийг А үнэлгээтэй төгссөн бол 50 хувь
- Биеийн тамирын спортын өндөр амжилт гаргаж байсан болон спортын зэрэг цолтой бол 20-40 хүртэл хувь, СИТИ Аянга багийн гишүүнээр сонгогсдон бол 50-100 хувь
- Сувилахуйн хөтөлбөрөөр элсэгч ЭЕШ-д 510 онооноос дээш оноо авсан бол 100 хувь
- Элсэгч нь 8 дугаар сарын 26-ны дотор сургалтын төлбөрөө бүтэн төлвөл 10 хувь
- Элсэгч нь 9 дүгээр сарын 01-ний дотор сургалтын төлбөрөө бүтэн төлвөл 5 хувийн тэтгэлэг олгоно.

Тайлбар: Дээр дурдсан тэтгэлгүүд нь хамтарсан хөтөлбөрт хамаарахгүй бөгөөд давхардуулж болохгүй.

6.2.Нэг гэр бүлийн 2 болон түүнээс дээш хүн элсэн орсон бол сургалтын төлбөрийн 30 хувийн тэтгэлэг олгоно.

### **Долоо. Элсэлтийн бүртгэл**

7.1.Улаанбаатар хотод элсэгчдийг 2023 оны 06 сарын 10-наас эхлэн өөрийн байранд болон онлайнаар бүртгэнэ.

#### **7.2.Бүрдүүлэх материал:**

- ЭЕШ-ын батламж
- Боловсролын үнэмлэх, гэрчилгээ, диплом

- Сурагчийн хувийн хэрэг
- Иргэний үнэмлэхийн хуулбар
- 3x4 хэмжээний цээж зураг 2 хувь
- Хөнгөлттэй нөхцөлөөр элсэх бол холбогдох материал
- Бүртгэлийн хураамж **20000** төгрөг

7.3. Элсэгчид СИТИ их сургуулийн албан ёсны веб хуудсаар дамжин элсэх хүсэлт гаргаж болно. Үүний тулд:

A. [www.citi.edu.mn](http://www.citi.edu.mn) хаягаар орж, бүртгүүлэх хэсгээс суралцах хөтөлбөрийн төрлөө сонгоно.

Б. Гарч ирэх цонхонд харагдах нүднүүдэд шаардлагатай мэдээллүүдийг үнэн зөв, кирилл үсгээр оруулан "Бүртгүүлэх" товчийг дарж хүсэлтээ бүртгүүлнэ.

В. "Бүртгүүлэх" товч дарснаар төлбөр төлөх хэсэг гарч ирэх ба төлбөрөө ухаалаг утас болон банкны аппликацийны Q руу цэсээр төлж бүртгэлээ баталгаажуулна.

7.4. Зохих шаардлагыг ханган элсэн орсон оюутан 2024 оны 8 дугаар сарын 26-аас 30-ны хооронд сургууль дээр ирж бүртгүүлэх бөгөөд онлайнаар бүртгүүлсэн элсэгчид 7.2-т дурдсан бичиг баримтуудын хуулбарыг /Бүрэн дунд боловсролын гэрчилгээг эх хувиар/ авчирч, Сургалтын бодлого зохицуулалтын газарт өгнө.

7.5. Хэрэв хуурамч бичиг баримт бүрдүүлсэн ба бүрдэл дутуу бол Элсэлтийн комисс тухайн элсэгчийг элсэлтийн бүртгэлээс хасах эрхтэй.

#### **Найм. Элсэлтийн холбоотой маргаан шийдвэрлэх**

8.1. Сургуулийн Элсэлтийн комисс нь тухайн элсэгчийн санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ.

8.2. ЭЕШ-тай холбоотой маргааныг сургуулийн Элсэлтийн комисс хариуцахгүй.